

© “Мөнгө, санхүү, баялаг” сэтгүүл 2017

ӨРИЙН ДАРАМТ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ СААРУУЛЖ, УДААН ХУГАЦААНД ЗОГСОНГИ БАЙДАЛД ХҮРГЭХ ТҮВШИНД ХҮРЛЭЭ

Д.Даваасамбуу¹

JEL ангилал:
D14, E44, E51,
E52, G01, G28

Түлхүүр үгс:
Зээл, бонд,
хүү, хуримтлал,
гадаад валютын
нөөц, ханш,
хямрал, эдийн
засгийн өсөлт

Хураангуй:

Энэхүү өгүүлэлд манай орны гадаад өр, түүний дотор арилжааны зээлийн дарамт нь эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд саадтай болсныг тоо, баримтаар харуулсан. Цаашлаад эмзэг, жижиг эдийн засагтай Монгол Улсын өрийн түвшинг өндөр хуримтлал, валютын асар их нөөцтэй БНХАУ, Япон, ХБНГУ зэрэг орны иргэд, аж ахуйн нэгжээс авсан дотоодын зээлтэй харьцуулж, иргэдийг тайтгаруулах оролдлого хийж буй улс төрчдийн үйлдэлд шүүмжлэлтэй хандсан байна. Эцэст нь өндөр хүүтэй гадаадын зээлийг хугацаанаас өмнө буцаан төлөх, эдийн засагт нэмүү өртөг бүтээх томоохон төслүүдийг урагшлуулахад чиглэсэн санхүү, мөнгөний бодлого явуулах талаар тодорхой санал дэвшүүлжээ.

1. Оршил

Монголбанкны цахим мэдээллээс үзэхэд, 2011 оны эхэнд Монгол Улсын өр нийтдээ 4 тэрбум ам.доллар байсан бол 2016 оны эцэст 24 орчим тэрбум ам.доллар болж, сүүлийн зургаан жилийн дотор бараг 20 тэрбум ам. доллараар нэмэгдсэн нь анхаарал татаж байна.

Эдгээр зээлийн өсөлтөд Оюутолгой, Тавантолгой зэрэг уул уурхайн ордын хөрөнгө оруулалтын зээл дийлэнх хувийг эзэлж байгаа ч Засгийн газрын шууд оролцоотой, бас баталгаатай зээлийн өр бараг 6 тэрбум ам.доллараар нэмэгдэж, 8.5 тэрбум ам.доллар болжээ.

Үүний дотор төсвийн алдагдлыг нөхөх, эцэст нь сонгуульд ялахын тулд ямар ч хүүтэй байх нь хамаагүй гадаадаас зээл авч, иргэдэд бэлнээр тараадгийг монголчууд төдийгүй гадаадын судлаачид шүүмжлэх болжээ.

Өнгөрсөн оны 9 дүгээр сард дэлхийд нэр хүндтэй “Файнэншл Таймс” сонинд гарсан нийтлэлд Монгол Улсаас өөр дэлхийн ямар ч улс 10 гаруй хувийн хүүтэй Засгийн газрын бонд гаргаж, ард түмэндээ тарааж өгдөггүй гэсэн байна. Үнэхээр 2016 оны эхээр Засгийн газраас гаргасан 500 сая ам.долларын “Мазаалай” бондын хүү нь 10.88 хувь бөгөөд түүний хүүд татвар төлөгчдийн мөнгөөр жил бүр гадагш 130 тэрбум орчим төгрөг төлж байна. Энэ нь арав гаруй сургууль, цэцэрлэг барихад хүрэлцэхүйц мөнгө юм.

¹ МУИС-ийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн ахлах багш. Цахим шуудан: ddalrai@gmail.com

Үүнийг Засгийн газар өндөр хүүтэй зээл авч, манай орны хувийн хэвшлийг олон улсын зах зээлд гарч, түүнээс бага хүүтэй зээл олох боломжийг хааж буй хэрэг гэж үзэж болно. Хүүгийн алдагдлаас гадна ханшийн зөрүүг нэмбэл төсөвт ямар дарамт үзүүлэх нь ойлгомжтой биз ээ. Хамгийн гол аюул нь төсвийн урсгал зардлын алдагдлыг гадаадын зээлээр нөхөж, Монголбанк нь алдагдалтай үйл ажиллагаа явуулж буйд оршино.

Ер нь дээрх 24 тэрбум ам.долларын зээлийн хүүд жилд төсвийн орлоготой бараг тэнцэх 4-5 их наяд төгрөгийг монголчууд бидний бүтээсэн үндэсний баялгаас гадагш төлж байна. Энэ нь экспортын орлогын 40 хувь буюу нэг ам.долларын экспортын 40 цент нь гадагшилж байна² гэсэн үг юм. Дөчин цент шүү!

Одооноос хэрээс хэтрээд буй зээлийг хаацайлж, хамгаалах гэсэн оролдлого ч хийгдэж байна. Монгол Улс шиг эмзэг, жижиг эдийн засагтай орныг зээл, санхүүгийн өндөр чадамжтай орнуудтай харьцуулан дүгнэж болохгүй гэдгийг зориуд анхааруулмаар байна. Дэлхийн улс орнуудад зээлийг тухайн орны эдийн засгийн хүч чадал, боломжид тохируулан ямар хэмжээтэй авч болохыг улс орнуудаар ангилсан байдаг ажээ. Дэлхийн банкнаас гаргасан ангиллын доод зэрэглэлд манай улс орж байна. Дээд зэрэглэлд нь том зээлдүүлэгч АНУ, Япон, ХБНГУ, БНХАУ орж байх жишээтэй.

Дэлхийн санхүүгийн нүүр царайг тодорхойлдог дээрх орнуудын талаарх мэдээ, мэдээлэл их гардаг нь ойлгомжтой, тэд ч дэлхий дахины өмнө үүрэг хүлээсэн орнууд билээ. “Файнэншл Таймс” сонины 2016 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн дугаарт: *“БНХАУ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэл дотоодын нийт бүтээгдэхүүний 241 хувьтай тэнцэж байна. Үүний дотроос компаниудын өрийн үлдэгдэл 17.8 их наяд ам.доллар буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 171 хувьтай тэнцэж байна”* гэжээ. Үүнийг бид өөрийн улсын өрийн хэмжээтэй жишиж, санаа амарч болохгүй юм. Хятадын энэ их өр, зээлийн цаад үндэслэл, шалтгааныг нь гаргаж, тайлбарлахгүйгээр манайхан хөнгөн хийсвэрээр өлгөн авч, БНХАУ ийм өртэй байхад бид зээл авах нь эрсдэлгүй мэтээр тайлбарлан тайвшруулах, эсвэл хятадыг “муучлах” гэсэн хандлагын аль аль нь буруу юм.

БНХАУ-ын их зээлийн эх үүсвэр нь хувь хүмүүс, байгууллагын хадгаламж, даатгал, чөлөөт мөнгөн хөрөнгө болно. Тэдний зээлийн бүх үлдэгдэл нь нийт хадгаламжийн 70 орчим хувьтай тэнцэж байна. Энэ нь үүний цаана зээлийн боломж байсаар л байна гэдгийг харуулах ажээ. Өөрөөр хэлбэл, хуримтлал, хадгаламжийн хэмжээ нь дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ээс хэд дахин давжээ. БНХАУ-ын ДНБ 2016 онд 12 их наяд ам.долларт ‘хүрэх’ тооцооноос үзэхэд, хуримтлал, хадгаламжийн хэмжээ нь 30 их наяд ам.долларын босгыг давах ажээ.

Тэгвэл монголчууд ямар хуримтлалтай вэ гэдгийг харъя. Монголбанкны мэдээгээр хадгаламж 8 их наяд төгрөг, банкны систем дэх дотоодын нийт зээл

² “Монголбанкны мэдээлэл” 2017 оны 1 дүгээр сар

12 их наяд орчим төгрөг байна. Түүн дээр Монголбанк, Засгийн газрын эх үүсвэргүй тараасан зээл нэмэгдэнэ.

Эндээс БНХАУ-д хадгаламж нь зээлийн үлдэгдлээс давж байхад манайд эсрэгээр байгааг харж болно. Монголын хэрэглээ, хуримтлал хоёрын харьцаа байгаа бол Хятадад бараг 50:50 буюу мөнгө их хуримтлуулдаг үндэстэн юм. Тэдний хуримтлалын түвшин Дэлхийн банкны мэдээгээр 2014 онд 49 хувь, гадаад урсгал тэнцлийн ашиг нь сүүлийн 20-иод жилд дунджаар ДНБ-ий 2-3 хувь, зарим үед 10 хувьд ч хүрч байжээ. Энэ бол дэлхийд хамгийн их хуримтлалтай улс гэсэн үг. Нөгөө талаас, гадаад валютын орлого нь гадагшилж байгаагаас байнга их байдаг бөгөөд улмаар гадаад валютын нөөц өдгөө 3 их наяд ам. доллар байна. Өмнөх жилүүдэд 4 их наяд ам. доллар байсан ажээ. Тиймдээ ч БНХАУ дэлхийн хамгийн том зээлдүүлэгч болж хувирчээ.

БНХАУ-тай нэгэн адил Япон, Өмнөд Солонгос, ХБНГУ, Голланд, Норвеги, Сингапур зэрэг улс нь экспортын баримжаатай хөгжлийг чухалчилдаг бөгөөд үүнийхээ үр дүнд дэлхийн томоохон зээл олгогч орон болсон юм. Ихээхэн өртэй мэтээр цоллож, бид өөрсдийгөө “зөвтгөх” шалтгаан болгодог орон бол Япон билээ. Япон Улс бол гадаадад өргүй цөөхөн орны нэг агаад бас их наяд ам.доллараар хэмжигдэх гадаад валютын нөөцтэй орон ажээ. Дотоод хуримтлал ихтэй болохоор ард түмнээс Засгийн газар зээлэх нь элбэг байдаг.

Монгол Улсын хувьд хувийн болон нийгмийн салбарт дарамт үүсгээд байгаа 24 тэрбум орчим ам.долларын хэмжээг багасгах, хүүг бууруулах талаар Засгийн газар, Монголбанк, арилжааны банкууд, Оюутолгой, Тавантолгой компани зэрэг зээлдэгч нар хамтран нэгдсэн бодлого, үзэл баримтлалтай ажиллах хэрэгтэй болжээ. Оюутолгой, Тавантолгойн ордын зарим эзэмшигчид авсан зээлийнхээ зарим хэсгийг төлсөн, хүүний хэмжээг бууруулсан тухай чихэнд чимэгтэй мэдээ саяхнаас дуулах болсон. Зөвхөн зээлийн хүүнд олон их наяд төгрөг гадагш алдаж, үндэсний баялаг, татварт ногдох орлого буурч, улмаар төсвийн татварын орлогын суурь сульдаж байна.

Бодит үйлдвэрлэл, бүтээгдэхүүн болж, хуримтлал үүсгэж буй гадаадын зарим зээлийг буруутгах үндэслэлгүй ч зээлийг дагаж шахааны бизнес, өндөр үнэтэй машин, тоног төхөөрөмж, ажил, үйлчилгээ уул, уурхайн томоохон ордуудад гарч байгаа тухай санал, шүүмжлэлийг нарийвчлан судлах учиртай. Нөгөө талаас төсвийн алдагдал нөхөх, улс төрийн амлалтад зориулагдаж, нэмүү өртөг огт бүтээхгүй зээл нэмэгдсэн нь харамсалтай. Үүний дотор Засгийн газарт хамааралтай, ойрын хугацаанд эргэн төлөгдөх болон өндөр хүүтэй зарим зээлийг зохицуулах шаардлага гарч байна. Мөн дэндүү өндөр хүүтэй буюу олон улсын санхүүгийн ойлголтоор дефолтод орсныг илэрхийлэхүйц өндөр хүүтэй, эдийн засагт эерэг гэхээсээ хүүний дарамт, сөрөг үр дагавар авчирч буй зарим төрлийн бондоос ойрын хугацаанд салах хэрэгтэй байна. Ингэхгүй бол Монгол Улсын эдийн засаг удаан хугацаанд өрийн дарамтад орж, жирийн иргэдийн бүтээсэн нэмүү өртгийг гадагш алдаж, өсөлт байхгүй болно. Хэрхэн зохицуулах вэ гэдэгт санаа өгөх үүднээс олон улсын

санхүү, түүний дотор бондын зах зээлийн өнөөгийн байдлын талаар товчхон тайлбарлая.

Олон улсын зах зээлд зээлийн хүү эрс буурчээ.

Санхүү, эдийн засгийн хямралын улмаас эдийн засгийн өсөлт удаашрах эсвэл бүр улмаар зогсонги байдалд орохоос сэрэмжлэн зайлсхийх, эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэхийн тулд мөнгө, санхүү, зээлийн механизмыг хэрхэн яаж ашиглаж байгааг тэргүүлэх зарим орны бодит жишээ баримтыг үндэслэн толилуулъя.

Бонд, хувьцааны дэлхийн зах зээлийн үнэ (хүү) 2016 онд ялимгүй өссөн нь бонд, хувьцаа эзэмшигчдэд нийцсэн таатай өөрчлөлт боллоо гэж үзэж байна. Уг өсөлт нь АНУ-ын 10 жилийн хугацаатай бондын хүү багахан өсч, 2016 оны эцэст 2 хувь давсан бол Японд 0.1 хувь, ХБНГУ-д 0.3 хувьд хүрсэнтэй холбоотой. Энэ бүхэн бол эдийн засгийн өсөлтийг урамшуулахын тулд хүүг бууруулах, валютын ханшийг сулруулах, эдийн засагт нийлүүлэх зээлийн хэмжээг нэмэгдүүлэх талаар өндөр хөгжилтэй орнууд сүүлийн үед дэс дараатай арга хэмжээ авч байгаагийн илрэл юм.

Япон, Еврогийн бүсийн улс, ИБУИНВУ зэрэг орнууд 2017 онд мөнгөний зөөлөн бодлогоо үргэлжлүүлнэ гэсэн таамаглал гарсан. Харин АНУ-ын Төв банк 2016 оны 12 дугаар сарын 15-нд өөрийн богино хугацаат зээлийн хүүг 25 нэгж хувиар нэмэгдүүлж, 0.75 хувь болгожээ. Гэхдээ л энэ нь маш доогуур хэмжээний хүү бөгөөд 2-3 жилийн дараа хэвийн буюу 3 хувь хүргэхэд зориулан хийгдэж буй анхны алхам гэж үзэж байна.

АНУ-ын Төв банкны үндсэн үүрэг болох ажлын байрыг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилтоо амжилттай биелүүлсэн гэж үзээд дээрх алхмыг маш болгоомжтой хийж буй хэрэг хэмээн бичиж байна. Ажилгүйдлийн түвшин АНУ-д 11 дүгээр сарын байдлаар 4.6 хувь байгаа нь Европынхоос 2 дахин доогуур байна. Хоёр жилийн хугацаатай бондын жилийн хүү дөнгөж 1.26 хувь байна.

Нэгэн зүйлийг тэмдэглэн хэлэхэд, АНУ-ын бондыг валютын нөөц ихтэй БНХАУ, Япон, Сингапур, ХБНГУ, Норвеги, Голланд зэрэг орон авдаг бол Япон, БНХАУ-ын бондыг хуримтлал, хадгаламж ихтэй иргэд нь голлон худалдан авдаг ажээ.

Японы Төв банкны ерөнхийлөгч К. Курода, түүний орлогч Н. Накосо нарын хэлснээр: Япон Улс мөнгөний бодлогын чанартай хоёр асуудлыг судалж байна: *нэгдүгээрт*, үнийг 2 хувьд хүргэж өсгөхөд саад болж буй хүчин зүйлсийг судалж илрүүлэх; *хоёрдугаарт*, зээлийн хүүг хасах болгосны эерэг, сөрөг нөлөөг судалж, дүгнэлт хийх ажээ.

Ерөнхийд нь дүгнэхэд, 2008-2009 оны санхүүгийн хямралаас хойш АНУ, Европын холбоо, Япон зэрэг өндөр хөгжилтэй орны зээлийн хүү түүхэнд байгаагүй доод түвшинд хүрчээ. Энэ нь хөгжиж буй орнууд луу хөрөнгө урсах нөхцлийг бүрдүүлж буй хэдий ч БНХАУ, Саудын Арабаас бусад орны

төлбөрийн тэнцэл алдагдалтай, төлбөрийн чадвар нь дутмаг байгаа болохоор тийш урсах хөрөнгийн урсгал бага хэвээр байна.

Олон орны үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш унасаар байна. Тухайлбал, өнгөрсөн оны 9 дүгээр сарын байдлаар өмнөх оныхтой харьцуулахад Оросын рубль 15.7 хувь, Бразилийн реал 23.1 хувь, Өмнөд Африкийн ранд 8.2 хувь, Мексикийн песо 11.3 хувиар тус тус унажээ. Өмнөд хөрш Хятадын юанийн ханш ч гэсэн бага зэрэг суларсан. Нөгөө талаар БНХАУ-ын эдийн засгийн хурд саарч, бөөний үнэ дефляци буюу бууралтад орсонтой холбогдуулан Ардын банк (Төв банк) нь сүүлийн жилүүдэд нийт банкуудыг зээл, мөнгөний эх үүсвэрээр илүүтэй хангаж, зээлийн хүүг хамгийн доод түвшинд байлгаж байна.

Ардын банкны хувьд өсөлтийг дэмжих, ихээхэн өр зээлтэй компаниудад зээлийн үйлчилгээний төлбөрийн дарамт үүсгэхээс сэргийлэхийн тулд мөнгөний зөөлөн буюу тэлэлтийн бодлогыг сонгохоос өөр аргагүй гэдэгт ихэнх хөрөнгө оруулагчид итгэлтэй байна.

Хөрөнгө оруулагчид нэлээд хөрөнгийг бондод оруулсан хийгээд эдийн засагт зээлийн эх үүсвэр элбэг болохоор бондын хүү багассан байна. Жишээлбэл, БНХАУ-ын Засгийн газрын арван жилийн хугацаатай бондын хүү 2014 оны 1 дүгээр сард 4.6 хувь байснаа 2016 оны 10 дугаар сарын сүүлч гэхэд 2.65 хувь болж буурчээ.

Гэхдээ АНУ-д хүүний хэмжээ өссөн, дэлхий дахинд таваарын бүтээгдэхүүний үнэ дахин өсөж сэргэх төлөвтэй болсон, БНХАУ-д инфляци сэргэх хандлагатай болсноос голчлон хамаарч 10 жилийн хугацаатай бондын хүү энэ оны эхнээс 3.28 хувь болон өсчээ. Мөн үйлдвэрлэгчийн үнийн индекс 2016 оны 8 дугаар сар хүртэл сүүлийн дөрвөн жил гаруйн хугацаанд хасах байснаа өнгөрсөн оны 11 дүгээр сар гэхэд оны эхнээс 3.3 хувиар өссөн ажээ. Гэхдээ л Хятадын Ардын банк мөнгөний зөөлөн бодлогоо чангатгахгүй болов уу гэсэн таамаглал байна. Банк хоорондын тооцоог санхүүжүүлдэг Ардын банкны репо зах зээлд бондын зээлийн хүү 2016 оны 8 дугаар сард 2.02 хувь байсан бол 2016 оны 12 дугаар сард дунджаар 2.2 хувь болжээ.

БНХАУ бондын зах зээлээ өнгөрсөн оны 5 дугаар сараас эхлэн гадаадынханд нээжээ. БНХАУ-ын 10 жилийн хугацаатай бондын жилийн хүү хувь байгаа нь харьцангуй өндөр ажээ. Энэ нь БНХАУ-тай зээлийн хэлэлцээ хийхэд баримжаалах хүү юм. Жишээ нь Монголбанкны юань, төгрөгийн солилцооны свопын үлдэгдэлд үүнээс илүү хүү тооцдог бол дээрх хүү нь үүнийг залруулах нэгэн үндэслэл болно.

Санаа авууштай зарим зүйлс

Дэлхий дахинаа бондын хүү хямд байгааг ашиглан зарим орнууд өмнөх онд гаргасан өндөр хүүтэй бондыг буцаан худалдан авч байна. Бага хүүтэй бондоор сольж буй хэрэг. Францын хөрөнгийн худалдааны “Klepierre” компани 2019, 2021 онд төлөх ёстой бондоо буцаан худалдан авч байна. Тэдний

худалдсан шинэ бондын хүү 1.25 хувь байгаа бол урьд нь гаргасан 2019 онд төлөгдөх бондын хүү нь 2.75 хувь, 2021 онд төлөх бондын хүү 3.25 хувь байна.

“Америка Меррил Линч” банкны судалгаагаар хөрөнгө оруулалтын зориулалттай европын бонд жилд 0.68 хувийн хүүтэй байгаа ажээ.

Өнгөрсөн оны сүүлчээс эхлэн тэргүүлэх гүрнүүд бондын хүүг буулгах талаар далайцтай арга хэмжээ авч, амжилтад хүрлээ. Өнгөрсөн оны 10 дугаар сард ИБУИНВУ-ын төв банк 70 тэрбум фунт стерлингийн активыг банк, санхүүгийн байгууллагаас худалдан авч, энэ хэмжээгээр мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөр баталлаа. Ингэснээр Их Британийн банк мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлсэн гурав дахь санхүүгийн байгууллага болжээ. Энэ арга хэмжээний үр дүнд бондын хүү мөн буурч, тухайлбал Их Британид бондын жилийн хүү 1.26 хувь хүртэл буурчээ.

Их Британи Европын холбооноос гарсны дараах хүндрэлээс сэргийлж, мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж байна гэх яриа бий. 10 жилийн хугацаатай бондын хүү Испанид 0.9 хувь, Ирландад 0.33 хувь байна.

Өндөр хүүтэй бондыг буцаан худалдан авах дээрх туршлагаас гадна хүүг багасгах, өр төлбөрийг саармагжуулах талаар улс орнуудад олон туршлага, арга хэрэгсэл бий. Бодлого боловсруулагчид аливаа өр төлбөрийн асуудлыг 3-5 хувилбартай боловсруулж, аль хор уршиг багатайг сонгох нь чухал гэсэн дүгнэлтийг өрийн удирдлагаар мэргэшсэн судлаач, эрдэмтэн Ли Бучхейфт, Миту Гулати нар “Засгийн газрын өрийн менежмент” номондоо тэмдэглэжээ. Тэд мөн банкны хямрал гарвал нийт эдийн засагт таагүй төдийгүй улсын төсвийн санхүүжилт баталгаагүй болох, эрх баригчид мөнгөгүй болохоороо амь алдахгүйн тулд банкны салбар, эсвэл гадаадаас зээл авдаг. Засгийн газрын өр, төсвийн санхүүжилт, банк, санхүүгийн систем хоёр нь хоорондоо хүйн холбоотой гэдгийг тусгайлан анхааруулсан байна.

Засгийн газар, банк ер нь аль алиндаа их тустай ч гэсэн Засгийн газрын өрийн хямрал нь санхүүгийн тогтолцоог хоосруулах, банкны хямрал нь Засгийн газрын санхүүг сүйрүүлэх боломжтой.

Дээрх мэдээлэл, санал дүгнэлт болон улс төр, эдийн засгийн гадаад, дотоод нөхцөл байдал, нийгмийн хийгээд хөгжлийн шаардлагыг бодвол гадаад өрийн асуудлаар ихээхэн хатуу байр суурь баримталж, зээл, хүүгийн дарамтаас гарахыг хичээх нь нэн чухал байна. Өндөр хүүтэйгээр өмнө гаргасан бонд, өрийн бичгийг эргүүлэн худалдан авч буй олон улсын шинэлэг туршлага, аргыг хэрэглэх шаардлагатай байна. Тухайлбал, Монгол Улсаас жилийн 5.5-аас дээш хүүтэйгээр гарга-сан бонд, өрийн бичгийг эгүүлэн худалдан авах, эсвэл бага хүүтэй зээлээр солих хэрэгтэй юм.

Өндөр хүүтэй зээл, бондоос буюу дээр дурдсан 10 гаруй хувийн хүүтэй “Мазаалай” бонд гэдгээс эхлэн зохицуулж, эдийн засагт үзүүлж буй дарамтыг дэс дараатай зөөлрүүлж чадвал эдийн засаг сэргэх боломж гарна. Өндөр хүүтэй бондыг буцаан худалдан авах хөрөнгийг гадаад, дотоодын бүх эх үүсвэрээс хайж олох талаар мэргэжлийн түвшинд судалж үзүүштэй.

Манайхан зээлдэгч, хөрөнгө оруулагчидтай шууд яриа хэлэлцээ хийхийн зэрэгцээ Өмнөд Солонгос, Латин Америкийн зарим орны туршлагыг судалж, монголын бондыг эзэмшдэг хөрөнгө оруулагчдын эзэн орон, тэдний төсөв, санхүүгийн байгууллагуудтай хэлэлцээ хийж, дэмжлэг авах нь чухал юм. Өндөр хүүтэй монголын бондыг эргүүлэн худалдан авахад зориулж, хүүгүй, эсвэл багахан хүүтэй зээл, тусламж олгохыг Монголыг дэмжигч зарим орнууд, олон улсын санхүүгийн байгууллагаас хүсэх нөхцөл боломж байна гэж үзэж болно.

Эдийн засгийг сэргээх, ажлын байр бий болгох, Оюутолгойн зэсийн баяжмал, Тавантолгойн нүүрсний орлого дахь монгол контентийг нэмэгдүүлж, гадаад төлбөрийн урсгал тэнцлийг сайжруулах хоёр талын ач холбогдолтой төмөр зам, цахилгаан эрчим хүчний үйлдвэрийг өөрсдийн хүчээр барих боломжтой гэдгийг мэргэжлийн хүмүүс ярьж байна. Эдгээрийг санхүүжүүлэх эх үүсвэрийг дотоодод бонд гаргах, гадаадын сонирхогчдод хувьцаалах болон зээлжүүлэх хэлбэрээр шийдвэрлэж болно гэж үзэж байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд, монголчуудын хөлс хөдөлмөр шингэсэн, чанартай, гүйлгээтэй бараа, бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд худалдаж чаддаг болох замаар өрийн хямралаас урьдчилан сэргийлж чадах билээ. Энэ нь урт хугацааны стратегийн зорилт юм.

Ном зүй:

- [1] Lastra R. M., Buchheit L. (2015). Sovereign debt management.
- [2] Greiner A., Finkle B. (2014). Public debt, sustainability and economic growth: Theory and empirics.
- [3] Financial Times (2017).
- [4] Монголбанк (2017). Монголбанкны мэдээлэл (1-р сар).